

ЖАРГАЛАНТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
3-Р СУРГУУЛИЙН 2018-2019 ОНЫ САНХҮҮГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Нэг. Шалгалтын зорилго

Ховд аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Жаргалант сумын ерөнхий боловсролын 3-р сургуулийн 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаа, төрийн өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдал, төсөв санхүү нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэнд дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан ажиллахад оршино.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт, аудитын албаны Улсын ахлах байцаагч 2020 оны 11 сарын 06-наас ажлын 10 хоногийн хугацаанд хяналт шалгалтаар ажиллав.

Гурав. Шалгалтанд хамрагдсан асуудал

Тус байгууллагуудын 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагааг Монгол улсын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар журмын хэрэгжилт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, үндсэн баримт материал, тайлан тэнцэлд тулгуурлан явуулав.

Дөрөв. Шалгалтанд хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Тус байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Хүүхдийн эрх хамгаалах тухай хууль, Монгол улсын бусад хууль эрх зүйн актуудыг удирдлага болгон ажил үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэн улсын төсвөөс батлагдсан төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, эргэлтийн хөрөнгийг олж бэлтгэн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилт тавин ажиллаж иржээ.

2018-2019 онд ээлтэй орчинд суралцагч бүрийн сурлагын амжилтыг ахиулж, ёс зүй, хариуцлагыг эрхэмлэсэн олон нийтийн оролцоот сургууль болно гэсэн зорилго тавин ажиллаж ирсэн байна.

Шалгагдах хугацааны хөрөнгийн эрх захирагчийн нэгдүгээр гарын үсгийг захирал Г, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Г нар зурж хяналт тавин ажиллаж ирсэн байна.

Тав. Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Тус байгууллага нь 2018 онд улсын төсвөөс 1220267.5 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 1550.0 мянган төгрөг, нийт 1221817.5 мянган төгрөгийн санхүүжилтаар ажиллагаагаа явуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1221868.9 мянган төгрөгийн төсөв бүрдүүлэн зарцуулсан байна.

Тус онд цалингийн зардалд 749972.4 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 90674.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 214254.6 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1731.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 258.0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 758.5 мянган төгрөг, ном хэвлэлийн зардалд 495.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардалд 1596.6 мянган төгрөг, хог хаягдалын зардалд 276.0 мянган төгрөг эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэлийн зардалд 614.0 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 33379.6 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 1759.1 мянган төгрөг, урсгал засварын зардалд 5571.7 мянган төгрөг, томилолтын зардалд 741.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 1667.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 354.1 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 6176.7 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 99798.3 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласаны тэтгэмжийн зардалд 11790.1 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Оны эхэнд 17.9 мянган төгрөгийн авлагатай байсан бол тайлант хугацааны эцэст 2382.9 мянган төгрөг болж, 2365.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Оны эхэнд 3930.9 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байсан бол тайлант хугацааны эцэст 1077.5 мянган төгрөг болж, 2853.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Тус байгууллага нь 2019 онд улсын төсвөөс 1324115.6 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 1550.0 мянган төгрөг, нийт 1325665.6 мянган төгрөгийн

санхүүжилтаар ажиллагаагаа явуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1325665.6 мянган төгрөгийн төсөв бүрдүүлэн зарцуулсан байна.

Тус онд цалингийн зардалд 908803.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 113600.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 224162.7 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1009.9 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 100.0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 594.5 мянган төгрөг, ном хэвлэлийн зардалд 594.6 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардалд 978.2 мянган төгрөг, хог хаягдалын зардалд 235.0 мянган төгрөг эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэлийн зардалд 238.7 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 38963.0 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 1208.1 мянган төгрөг, урсгал засварын зардалд 5742.6 мянган төгрөг, томилолтын зардалд 196.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 594.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1155.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 6688.9 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардалд 20800.1 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Оны эхэнд 2382.9 мянган төгрөгийн авлагатай байсан бол тайлант хугацааны эцэст 3657.2 мянган төгрөг болж, 1274.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Оны эхэнд 1077.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байсан бол тайлант хугацааны эцэст 54.4 мянган төгрөг болж, 1023.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Зургаа. Өмнөх шалгалтын талаар:

2019 онд 3-р сургуулийн 40-н жилийн ойн тайлангын дансыг бага ангийн багш Д.Энэбиш, газар зүйн багш Б.Нямцоож, биологийн багш Г.Наранцэцэг, нягтлан бодогч З.Гиваахүү, нярав Х.Баасандорж нар ойн хандивын мөнгийг тус сургуулийн хамтын сангын дансаар хамт олны хурлаараа шийдэж төвлөрүүлэн зарцуулсан байна.

Тус ойгоор нийт 49.902.000 төгрөгийн орлого бүрдүүлжээ. Дээрх орлогыг задалбал: Эцэг эхийн тэмцээн урлагийн тоглолтийн орлогоос дүн 10.457.000 төгрөг, багш ажилчдын хандив 13.215.000, төгсөгчдийн хандив 25.830.000 төгрөг, банзны үнээс 400.000 төгрөгийг тус тус бүрдүүлэн зарцуулсан байна.

Нийт зарцуулалт нь 49.902.000 төгрөг байна.

40 жилийн ойд 108.149.800 төгрөгний хөрөнгө хандив тусламжаар ирсэнийг үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэж авсан байна.

Долоо. Өмнөх шалгалтын талаар:

2018, 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар 460.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, 234.7 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй байсныг залруулсан байна. Мөн Сургуулийн цайны газрыг тус онд иргэн Н.Алтанцэцэгт түрээслэсэн боловч түрээсийн гэрээ байгуулаагүй, түрээсийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, сахилгын арга хэмжээ авагдсан албан хаагчдын сахилгын арга хэмжээг тооцоогүйтэй холбоотой 320.1 мянган төгрөгийн акт тогтоосон байна.

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар Монгол улсын БСШУСС-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/823 тушаалаар өр барагдуулахаар тус байгууллагын нэмэлт дансаар 6100.0 мянган төгрөг олгосноос зориулалт бусаар буюу шагналд 706.0 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илрүүлж зөвлөмж хүргүүлсэн байна.

Найм. Тус байгууллагын ололттой талууд:

Орон нутгийн хөгжлийн сангаас заалны шал солихоор 5000000 төгрөгний хөрөнгийг шийдүүлж засвар хийсэн.

Хүүхдийн 8 суудалтай эко ОО-н төсөл хэрэгжиж төслийн францчууд ирж багш, ажилчдад эко ОО-н ашиг тус, зөв зохистой ашиглах талаар сургалт явуулсан байна.

Аймгийн нийтийн номын сангаас зохион байгуулсан “Шувуун саарал” тэмцээнд сургуулийн 7а ангийн сурагч Мөнхгэрэл 2-р байр, 10г ангийн сурагч Хосбуян 3-р байр “Ган үзэг” тэмцээнд Гадаад хэлний багш Д.Мөнхтуяа тусгай байр эзэлсэн.

Ж.Чулууны нэрэмжит хөгжмийн наадамд манай сургуулийн “Аялгуут эгшиглэн” хамтлаг 1-р байр эзэлсэн.

Ширээний теннисний өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн насны ангилалаар явагдаж багш Н.Бөхболд багшийн бэлтгэсэн шавь нар ангилал тус бүрээс медаль авсан.

“Дуулиан-2020” тэмцээнээс манай сургуулийн 86 ангийн охидууд 2-р байр эзэлсэн.

Математикийн багш Т.Амгаланбаатарын бэлтгэсэн шавь Увс аймагт болсон баруун бүсийн Математикийн олимпиадад Б.Наранжаргал хүрэл медаль, Баян-Өлзий аймагт болсон бүсийн математикийн олимпиадад Б.Наранжаргал хүрэл медаль тус тус хүртсэн.

Японы хүүхдийг ивээх сангийн хүүхдийн боловсролд тэгш хамруулан сургах төсөл албан ёсоор хэрэгжиж эхэллэсэн ба удахгүй тусгай хэрэгцээт хүүхдийн иж бүрэн кабинет байгуулагдан төсөл амжилттай хэрэгжих гэрээ байгуулан ажиллаж байна.

Ховд аймгийн багш сурагчдын дунд мэргэжлийн хичээлийн олимпиад явагдаж тус сургууль нь багаараа 4-р байранд шалгарсан.

Математикийн багш Ц.Сайханжаргал багштай 2007 оны төгсөгчид багшийнхаа ангийн засвар тохижилтыг 3 сая төгрөгөөр хийж өгсөн. Засварт 4 цонхыг вакум болгож хананы хуучин замаскийг хусаж ахиж замаск татсан, хана шал будсан. Хаалга сольсон байна.

Гадаад хэлний багш Ц.Дэлгэрмаа багшийн 2014 оны төгсөгч нар англи хэлний кабинетын 4 цонхыг вакум болгож кабинетийн тохижилтын үйл ажиллагаа хийж өгсөн.

Сургуулийнхаа номын санг өөрсдийн боломжоор тохижуулж шинэчлэсэн.

Сургуулийн 1997 оны төгсөгч н.Баасандаш гэр бүлийн хамт сургуульд ангийн самбар хандивласан, 2004 оны төгсөгч нар сургуулийн гадна сагсан бөмбөгийн талбайг байгуулсан, ахмад багш Н.Эрдэнэчимэг үр хүүхдүүдийнхээ хамт их гарын ятга сургуульдаа хандивласан, сургуулийн хашааг шинэчилэн Евро хашаа барьсан, хайрхан багийн ахмадууд сургуулийн хашаанд мод тарьж өгсөн зэргээс харахад сургуулийн орчин нөхцөл сайжирсан байна.

Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт 1, 5, 10 дах жилдээ ажиллаж байгаа багш нарыг үндсэн сургалтанд жил бүр хамрууладаг ба сургуулийн нэр бүхий 9 багш, сургалтын менежерүүд хамрагдсан байна.

2018-2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан зэрэг ололттой талууд байна.

Ес. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар:

Нэр бүхий 5 багш, ажилтанд сургуулийн захирлын тушаалаар сахилгын шийтгэл тооцсон байхад үр дүнгийн нэмэгдэл цалинг улирал бүр 758091 төгрөгийг тооцон олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтууд, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.3 дахь заалтыг,

Нэр бүхий 13 багш, ажилтанд зарим саруудад ур чадварын нэмэгдлийг цагийн тооцоонд захирлын тушаал шийдвэрээс тодорхой хувиар илүү тооцон 502423 төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6 дахь заалтуудыг, Засгийн газрын 2018 оны 382-р тогтоолын 4 дүгээр хавсралтын 2 дахь заалт, БСШУ-ны сайд, Сангийн сайдын 2010 оны 08 дугаар сарын 16-ны 362/112/183 тоот тушаал, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг,

2018-2019 онд яамдын жуух, тэргүүний ажилтнаас бусад төрийн одон медалиар шагнагдсан багш, ажилтан нийт 9 хүнд 900000 төгрөгийг төсвөөс зарцуулсан нь 6 дугаар зүйлийн 6.4.8, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалтуудыг, БСШУ-ны сайдын 2010 оны 451-р тушаалыг,

2019 оны 12 сарын 14-ны А/07 тоот сургуулийн захирлын тушаалаар нэр бүхий 15 багш ажилтаны 1 өдрийн цалинг хасаж тооцох тушаалыг зөрчиж 675198 төгрөгийг суутган аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг, Сургуулийн захирлын 2019 оны 12 сарын 14-ны өдрийн А/07 тоот тушаалыг,

2019 оны 09 сард Х ХХК-д тарагны үнэ 174 хүүхдээр тооцож, 102000 төгрөгийг шилжүүлсэн ба анхан шатны бүртгэл болох ирцийн бүртгэлгүй, тухайн байгууллагын нэхэмжлэлээр тооцон гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6 дахь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

Сургуулийн захирлын 2019 оны Б/40 тоот тушаалаар 2019 оны 09 сарын 05-ны өдрийн тушаал зөрчиж 99948 төгрөгийг илүү тооцон олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6 дахь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалтуудыг,

Шалгалтаар Ховд аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын 3-р сургуульд нийт 3037660 төгрөгийн зөрчил илрүүлж, 2137660 төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар улсын ахлах байцаагчийн актыг тус тус тогтоож 900000 төгрөгийн зөрчлийг арилгахаар хугацаатай үүрэг болголоо.

Арав. Дүгнэлт:

Тухайн байгууллага нь тайлан тэнцэлийг хуулийн хугацаанд гаргаж, зохих байгууллагуудад хянуулан 2018-2019 онд зөрчилгүй санал дүгнэлттэй тушааж хэвшсэн анхан шатны баримтын бүрдэл аж ахуйн анхан шатны тооцоо бодолт хэвийн хэмжээнд байгаа боловч тушаал шийдвэргүй нэмэгдэл цалин хөлс олгосон, захирлын тушаалын хэрэгжилт хангаагүй илүү тооцон боддог, суутган тооцон хийгээгүй, үдийн цайны ирцийн бүртгэл зөрүүтэй, анхан шатны баримт дутуу байхад тооцоо хийсэн, сахилгын шийтгэлтэй багш ажилтанд ур чадвар, үр дүнгийн нэмэгдэл олгосон зэрэг зөрчлүүд байна.

Арван нэг. Цаашид авах арга хэмжээний санал:

Жаргалант сумын 3-р сургуульд:

1. Аливаа хөрөнгө мөнгийг бүрдэл болсон, хүчин төгөлдөр анхан шатны үнэн зөв баримтаар гүйлгээ хийж байх.
2. Цалин хөлс бодохдоо цагийн тооцоо, байгууллагын даргын тушаал шийдвэрийн дагуу олгож хэвших.
3. Төсвийн хөрөнгийг төсөвлөгдсөн хэмжээнд зохих хууль эрх зүйг мөрдөх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулахад анхаарах./Тухайлбал Засгийн газрын тогтоол зөрчиж ихээхэн хэмжээний шагнал урамшуулалд мөнгө зардаг асуудлыг таслан зогсоох/
4. Сахилгын шийтгэлттэй албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн нэмэгдэл цалинг олгохгүй байх.
5. Тушаал шийдвэрийг зөрүүтэй гаргаж, ажлын хариуцлага алдсан бичиг хэргийн ажилтанд хариуцлагын арга хэмжээ тооцон ажиллах.

6. Шалгалтаар илэрсэн зөрчилтэй холбоотой ажил сайжруулах хугацаатай үүрэг өгч, биелэлтийг тооцож ажиллах ба шалгалтаар илэрсэн зөрчлийг арилган тайланг 2020 оны 12 сарын 10-ны дотор ирүүлэх шаардлагатай.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА

